

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	11
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	12
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Албан шаардлага	18
5.2 Зөвлөмж	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	23
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	23
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	25
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	28

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТЗБАХ	Техник зохион байгуулалтын арга хэмжээ
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024-03-15 № 07/729

талай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын далгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцол Багануур ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй дараах алдаа, зөрчил нь бидний тогтоосон 1,610.7 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Тайлант оны эцэст 989.3 сая төгрөгийн өр төлбөр, 3,005.3 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй ба 535.8 сая төгрөгийн өр төлбөр, 1,550.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэл насжилт өндөртэй буюу авлага, өглөгийг хугацаанд нь барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй;
- Тус байгууллагад бүртгэлтэй 8 газар эзэмших эрхийн үнэлгээг хийгээгүй, санхүүгийн тайланд тусгаагүй;
- Санхүүгийн тайланд тусгагдсан 1,167.0 сая төгрөгийн нөөц өр төлбөртэй холбоотой баримт, тооцооллыг аудитад ирүүлээгүй тул тус үлдэгдлийг үнэн зөв эсэхийг баталгаажуулах боломжгүй зэрэг зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.6, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид ад хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 3 дугаар зүйлийн 3.8 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Z:\Улаанбаатар_Бичиг\2024\03\05 ШААГ-38.Docx

0001051856

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант жилд хөрс хуулалт, нүүрс тээврийн үйл ажиллагаанд нэн шаардлагатай томоохон машин, тоног төхөөрөмжийг шинээр худалдан авсан, мөн сүүлийн жилүүдэд хийгдээгүй байсан технологийн авто машинуудын хөдөлгүүр болон томоохон их засваруудыг хийж, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 34,893.2 сая төгрөг зарцуулсан байна.

Багануур ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар 210,507.5 сая төгрөгийн 62 алдаа, зөрчил илэрснийг ажлын хэсэг томилон шуурхай арга хэмжээ авч ажиллан 49 алдаа зөрчлийг залруулан ажилласан байна.

Аудитын гол асуудал

Багануур ХК нь 242,920.5 сая төгрөгийн хуримтлагдсан өр төлбөрийн үлдэгдэлтэй, өр төлбөрийг гэрээнд заасан хугацаанд барагдуулаагүйгээс худалдан авах ажиллагаа зохион байгуулахад хүндрэл үүсч, оролцогч компаниудын тоо буурах, гэрээний гүйцэтгэлийг дүгнэх боломжгүй болох, урт хугацаат зээлийн эргэн төлөлт хийгдэхгүй зэрэг сөрөг үр дагавар үүсэж байгаа нь Эрчим хүчний зохицуулах хорооноос нүүрсний борлуулалтын үнэ тарифыг өртгөөс нь бага үнээр тогтоож ирсэнтэй холбоотой ба үүнээс компанийн ашигт ажиллагаа болон тасралтгүй үйл ажиллагаанд эрсдэл үүсэхээр байна.

Бусад асуудлын хэсэг

Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 19 зорилтын хүрээнд 47 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 91.6 хувьтай гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй бөгөөд байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэх болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	3,982,323,532.05	2,417,234,743.19
1.1.2	Дансны авлага	10,010,013,641.16	4,547,818,310.13
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	738,531,557.44	27,915,379.57
1.1.4	Бусад авлага	74,240,000.00	3,546,675,927.60
1.1.8	Бараа материал	45,001,808,854.70	49,354,185,878.94
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	10,838,248,771.63	-
	Эргэлтийн хөрөнгийн дүн	70,647,262,358.98	63,603,789,147.13
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	151,858,946,967.51	169,952,205,306.91
1.2.2	Биет бус хөрөнгө	4,358,225,684.80	4,600,586,254.79
1.2.3	Уул уурхайн хөрөнгө /Харс хуулагт/	27,209,712,833.10	25,583,088,822.70
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	998,767,331.34	999,767,331.34
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	764,393,387.00	764,393,387.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		3,609,958,908.70
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	185,191,046,203.55	201,880,028,902.74
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	255,838,308,560.53	265,483,818,049.87
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	52,405,529,509.13	60,720,143,664.51
2.1.1.2	Цалингийн өглөг	2,521,958,781.00	2,616,642,414.86
2.1.1.3	Татварын өр	48,087,404,572.38	53,284,067,637.36
2.1.1.4	НДШ-ийн өглөг	12,179,131,636.82	8,287,925,455.68
2.1.1.5	Богино хугацаат зээл	46,716,839,284.27	3,786,628,727.10
2.1.1.6	Хүүний өглөг	2,579,831,249.31	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	12,988,712.50	12,988,712.50
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	1,840,742,814.38
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	431,594,370.84	50,788,049.31
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	164,935,258,116.25	130,379,907,475.71
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	47,395,869,334.18	102,185,389,999.85
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	1,167,266,443.09	1,167,266,443.09
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	8,103,541,421.55	9,187,980,486.21
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	56,666,677,198.82	112,540,616,929.15
2.2	Өр төлбөрийн нийт дүн	221,601,935,315.07	242,920,524,404.86
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч-төрийн	1,573,077,000.00	1,573,077,000.00
2.3.2	- хувийн	524,359,000.00	524,359,000.00
2.3.8	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	60,685,388,076.98	60,685,388,076.98
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(28,546,450,831.52)	(40,219,530,431.97)
2.3.11	Эздийн өмчийн дүн	34,236,373,245.46	22,683,293,645.01
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	255,838,308,560.53	265,483,818,049.87

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	160,262,944,907.10	210,096,473,086.23
2	Борлуулалтын өртөг	163,002,892,433.64	204,142,122,501.47
3	Нийт ашиг(алдагдал)	(2,739,747,526.54)	5,954,350,584.76
4	Түрээсийн орлого	20,563,400.00	34,070,947.73
5	Хүүгийн орлого	-	13,894,581.72
6	Ногдол ашгийн орлого	-	12,863,696.52
8	Бусад орлого	782,792,383.86	388,737,611.97
9	Борлуулалт, маркетингийн зардал	567,138,179.19	647,053,456.31
10	Ерөнхий ба удирдлагын зардал	21,508,033,983.12	13,265,655,474.83
11	Санхүүгийн зардал	3,085,094,742.48	2,885,116,635.38
12	Бусад зардал	5,600,353,774.58	885,872,898.97
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(984,174,801.56)	1,566,308,195.77
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(33,659,185,223.81)	(9,515,472,847.02)
19	Орлогын татварын зардал	25,020,000.01	1,389,458.17
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(33,684,205,223.82)	(9,516,862,305.19)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(33,684,205,223.82)	(9,516,862,305.19)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Орлогын нийт дүн	(33,684,205,223.82)	(9,516,862,305.19)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Тусгай зориулалтын невцийн сан	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	8,482,120,309.04	7,284,912,713.63	78,559,857,089.63
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(6,482,120,309.04)		(8,482,120,309.04)
Залруулсан үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	-	7,294,912,713.63	70,077,736,790.61
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				(33,684,205,223.62)	(33,684,205,223.62)
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт				(2,157,158,321.33)	(2,157,158,321.33)
Зарласан ногдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
2022 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	-	(28,546,450,831.52)	34,236,373,245.46
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
Залруулсан үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	-	(28,546,450,831.52)	34,236,373,245.46
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(9,516,862,305.19)	(9,516,862,305.19)
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт				(2,156,217,295.26)	(2,156,217,295.26)
Зарласан ногдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
2023 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	-	(40,219,530,431.97)	22,563,293,645.01

(Төгрөгөөс)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	161,237,556,096.93	211,205,772,188.83
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	160,957,619,734.73	210,909,990,145.16
1.1.4	Буцаан авсан албан татвар	223,252,668.73	269,520,748.42
1.1.6	Бусад мөнгөн орлого	58,683,693.47	26,261,295.25
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	144,019,366,656.87	201,263,308,232.25
1.2.1	Ажиллагчдад төлсөн	48,049,400,143.33	41,605,342,476.92
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	9,821,333,442.71	17,278,689,407.40
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	32,105,981,293.76	77,268,930,989.11
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	39,813,145,427.81	50,828,908,506.36
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	132,547,301.21	1,044,881,385.10
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	14,907,385,790.66	10,656,724,554.40
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,189,593,251.38	2,379,830,912.96
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	17,218,189,440.06	9,942,463,956.58
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	13,801,304.98
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		13,801,304.98
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	14,294,679,711.64	25,517,179,633.48
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	14,250,000,664.54	25,406,785,735.48
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	44,679,047.00	110,393,798.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(14,294,679,711.64)	(25,503,378,228.50)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	31,273,553,667.00	55,004,840,525.00
3.1.1	Зээл авсан, ерийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	31,273,553,667.00	55,004,840,525.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	31,268,648,788.97	41,008,796,217.77
3.2.1	Зээл, ерийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	31,268,648,788.97	41,008,796,217.77
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,904,868.03	13,996,044,307.23
4	Валютын ханшийн зөрүү	3,866,126.79	(218,824.17)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,932,280,723.34	(1,565,088,788.86)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,060,042,808.71	3,982,323,532.05
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,982,323,532.05	2,417,234,743.19

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны /мянган төгрөг/			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
А Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт биетээр							
1	Нүүрс гаргалт	мян тн	4,404.5	4,625.0	4,648.4	23.4	100.5
2	Нүүрс борлуулалт	мян тн	4,418.1	4,625.0	4,628.1	3.1	100.1
3	Хөрс хуулалт	мян м3	16,509.9	17,495.0	17,866.7	371.7	102.1
4	Нийт уулын цул	мян м3	27,645.6	28,058.9	29,098.1	1,039.2	103.7
Б Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн үнийн дүнгээр							
5	Нийт орлого	мян төг	162,787,153.3	214,584,044.5	212,597,765.7	(1,988,278.8)	99.1
6	Үүнээс: Цэвэр орлого	мян төг	160,262,944.9	212,266,321.3	210,096,473.1	(2,169,848.2)	99
В Нийт зардал							
7	Үүнээс: Удирдлагын зардал	мян төг	8,348,567.7	11,445,090.6	13,285,655.5	1,820,564.9	115.9
8	Нийлмийн зардал	мян төг	2,756,750.2	3,541,444.9	3,770,400.4	228,955.5	108.5
Г ТТӨА							
9	Цэвэр ашиг	мян төг	(33,684,595.6)	(9,765,997.5)	(9,516,862.3)	249,135.2	97.4
10	Төсөвт төлөх нийт төлбөр	мян төг	40,108,247.0	47,783,812.7	47,099,246.9	(684,565.8)	98.6
11	Үүнээс: Орлогын татвар	мян төг	25,020.0	-	-	-	-
12	Ажиллагсдын тоо	хүн	1,123.0	1,123.0	1,117.0	-6.0	99.5
13	Цалингийн сан	мян төг	43,638,837.3	53,654,893.7	52,855,302.2	(799,391.5)	98.6
14	Авлага	мян төг	10,823,785.2	13,154,910.9	8,197,289.6	(4,957,621.3)	62.3
15	Өр төлбөр	мян төг	221,601,935.3	240,657,061.4	242,920,524.4	2,263,463.0	100.9
16	Үүнээс: Богино хугацаат өглөг	мян төг	184,935,258.1	159,506,979.1	130,379,907.5	(29,127,071.7)	81.7
17	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	төгрөг	0.83	0.95	0.95	-	100.1
18	Харенгө оруулалт	мян төг	13,824,101.7	42,545,013.8	34,893,194.9	(7,651,818.9)	82
19	1 тонн нүүрсний өртөг	мян төг	44,601.4	48,508.1	47,783.0	(725.1)	98.5
20	Хөрс хуулалтын коэфф	м3/тн	3.7	3.8	3.8	0.1	101.6
21	Аваар саатал	тоо	-	-	-	-	-
22	Ус шүүрүүлэлт	мян.м3	5,291.0	5,320.0	5,377.2	57.2	101.1
23	Байгаль орчин шинэчлэлт, инновацийн асуудлыг шийдсэн байдал	мян төг	227,794.6	777,756.7	436,938.7	(340,817.0)	56.2

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Багануур ХК нь эрхэм зорилгоо "Тогтвортой хөгжлийг хангасан, мэдлэг инновацид суурилсан үндэсний тэргүүлэгч компани болоход оршино" гэж тодорхойлжээ.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг "Байгаль орчинд ээлтэй, сөрөг нөлөөгүй, дэвшилтэт техник технологийг ашиглан үйлдвэрлэлийн үйл ажиллагааг явуулж, хэрэглэгчдийг стандарт чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр хангаж, хувьцаа эзэмшигчдийн эдийн засгийн ашиг сонирхлыг эрхэмлэсэн үр ашигтай бизнес эрхлэхийг үндсэн зорилгоо болгон нүүрс олборлолт, баяжуулалт, боловсруулалт, борлуулалтын чиглэлийн үйл ажиллагаа явуулна" гэж тусгасан байна. Үүнд:

- Нүүрсний олборлолт, баяжуулалт, боловсруулалт, борлуулалт
- Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа
- Багануур сувилал ХХК-ийн үйлчилгээ
- Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын олгосон зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд нийт хувьцааны 75 хувийг төрийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа "Эрдэнэс Монгол" ХХК, 21.06 хувийг "Монголиан коал корпорейшн" ХХК, 3.94 хувийг аж ахуйн нэгж, хувь хүмүүс эзэмшиж байна. Мөн тус компани нь "Багануур сувилал" ХХК-ийн хувьцааг 100 хувь, "Мон цахим" ХХК-ийн хувьцааны 46 хувийг тус тус эзэмшдэг.

Уул уурхайн, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/16 дугаар тушаалаар баталсан "Уурхай, уулын баяжуулах, үйлдвэрийг ашиглалтанд хүлээн авах журам"-ын 2.1.2 дахь заалтыг үндэслэн Багануур ТӨХК-ийн нүүрсний ил уурхайг ашиглалтанд авах Улсын комиссын шийдвэр 2021 оны 12 дугаар сарын 24 нд гарсан. Энэ шийдвэртэй холбоотой 2022 оны эхний улиралд уурхайн дунд хугацааны ТЭЗҮ-г боловсруулж батлуулснаар уурхайн хүчин чадал 4-10 сая тоннд хүрч борлуулалт нэмэгдэх боломжтой болсон байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Тус компани нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын зөвлөлийн 1977 оны 368 дугаар тогтоолоор 1978 онд үүсэн байгуулагдсан ба Төвийн эрчим хүчний системийн харьяа Дулааны цахилгаан станцуудыг нүүрсээр хангах зорилгоор ажиллаж эхэлсэн. 1995 онд хувьцаат компани, 2012 онд "Эрдэнэс Монгол" ХХК-ийн охин компани болон статус нь өөрчлөгдсөн ба жилд 4 сая тонн нүүрс олборлох хүчин чадалтай. Компани эрчим хүч үйлдвэрлэгч байгууллагуудыг нүүрсээр хангахаас гадна хот орчмын айл өрх, аж ахуйн нэгж, ойр орчмын сумуудын уурын зууханд нийлүүлдэг. Компанийн удирдах дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд түүнийг төлөөлөн удирдан ажиллах байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна.

Тус компани нь Компанийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Ашигт малтмалын тухай хууль
- Төрийн хэмнэлтийн хууль
- Зөвшөөрлийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Зөвшөөрлийн тухай хууль

- Багануур ХК-ийн дүрэм
- Эрдэнэс Монгол ХХК-ийн дүрэм
- Терийн өмчит компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах журам
- Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулах журам
- Ажилтны мэдээллийг авах, боловсруулах, ашиглах, хадгалах журам
- Сургалтын тэтгэлэг олгох журам

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилготой хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Багануур ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилууллын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Компани нь Эрдэнэс Монгол ХХК-ийн группын хэмжээнд 2018 онд баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байна. Энэ нь Багануур ХК-ийн үйл ажиллагааны онцлогт нийцээгүй байна. Компанийн бизнесийн үйл ажиллагаа болон бүртгэлийн нийтлэг зарчмыг хангахгүй, шинэчлэгдэн мөрдөж байгаа НББОУС болон СТОУС-ыг хэрэглээг тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль, тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа талаар өмнөх аудитаар зөвлөмж өгсөн ч одоог хүртэл шийдвэрлээгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Багануур ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант онд бараа материалын үнэ цэнийн бууралтын нормыг шинэчлэн тогтоож, захирлын тушаалаар батлан, мөрдөж ажилласан боловч нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тус өөрчлөлтийг оруулаагүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,645.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Ү/сая төгрөгөөр
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	3,982.3	2,417.2	(1,565.1)
Нийт авлага	10,823.8	8,222.4	(2,601.4)
Бараа материал	45,001.9	49,354.2	4,352.3
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	10,839.2	-	(10,839.2)
Эргэлтийн бус хөрөнгө	-	3,610.0	3,610.0
Үндсэн хөрөнгө	185,191.0	201,880.0	16,689.0

Багануур ХХ-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Нийт хөрөнгийн дүн	255,838.3	265,483.8	9,645.5
Богино хугацаат өр төлбөрийн дүн	164,935.3	130,379.9	(34,555.4)
Урт хугацаат өр төлбөрийн дүн	56,666.7	112,540.6	55,873.9
Эздийн өмч	34,236.4	22,563.3	(11,673.1)
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	255,838.3	265,483.8	9,645.5

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, богино хугацаат өглөг, урт хугацаат өр төлбөр, эздийн өмч дансдуудад материаллаг дүнгээр дараах өөрчлөлт гарсан байна.

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,417.2 сая төгрөг болж, 1,565.1 сая төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулсантай холбоотой байна.
- Нийт авлагын үлдэгдэл 8,222.4 сая төгрөг болж, 2,601.4 сая төгрөгөөр буурсан нь борлуулалтын авлагыг харилцагч байгууллагууд хугацаанд нь төлж барагдуулсантай холбоотой байна. Мөн найдваргүй авлагыг нөөцийн бужуу хасагдууллын аргаар тооцдог, тайлант хугацаанд 154.3 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц байгуулж, 262.5 сая төгрөгөөр авлагын нөөцийг бууруулсан байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 49,352.3 сая төгрөг болж 4,352.3 сая төгрөгөөр өссөн нь нүүрс 1,151.9 сая, бензин түлш 1,067.4 сая, Комацугийн сэлбэг хэрэгсэл 1,375.4 сая, засварын сэлбэг 540.2 сая, тослох материал 241.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн. Өвлийн их ачааллын үед нүүрсний олборлолт нэмэгдсэн, үйдээрлэлийн хэвийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай түлшний нөөцийг нэмэгдүүлсэн, мөн Оросын холбооны улсад үүссэн цэрэг дайны үйл ажиллагааны улмаас нэн шаардлагатай сэлбэг бараа материалын үнэ өссөнтэй холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд бүртгэлтэй таван жилээс дээш насжилттай 1817 нэр төрлийн 4,071.9 сая төгрөгийн бараа материалд үнэ цэнийн бууралт тооцон тайлагнасан.
- Урьдчилж толсон зардал дансны үлдэгдэл 10,839.2 сая төгрөгөөр буурч үлдэгдэлгүй тайлагнагдсан нь сэлбэг бараа материал худалдан авахад төлсөн НӨАТ-ын 1,734.1 сая төгрөгийг нэмэгдсэн өртгийн өглөгийн дансанд бүртгэсэн, үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд урьдчилж төлсөн 6,355.8 сая төгрөгийг ажлын гүйцэтгэлийн актыг үндэслэн үндсэн хөрөнгөнд капиталжуулан бүртгэсэн мөн үндсэн хөрөнгийн хувь тэнцүүлсэн НӨАТ-ын тооцоо дансны үлдэгдэл 3,609.9 сая төгрөгийг аудитын залруулгын дагуу эргэлтийн бус хөрөнгийн ангилалд бүртгэснээс шалтгаалсан.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 201,880.0 сая төгрөг болж 16,689.0 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалт, ТЗБАХ-ний төлөвлөгөөний дагуу машин тоног төхөөрөмжийг шинэчлэх зорилгоор 16,848.1 сая төгрөгийн өртөг бүхий 6 ширхэг технологийн автомашин, 1,693.2 сая төгрөгийн 9 ширхэг тээврийн хэрэгсэл, 10,239.9 сая төгрөгийн бусад үндсэн хөрөнгө нийт 28,781.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шинээр худалдан авч, 20,800.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг капиталжуулан бүртгэсэнтэй холбоотой байна.
- Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 130,379.9 сая төгрөг болж 34,555.4 сая төгрөгөөр буурсан нь богино хугацаат өр төлбөрийн дансанд бүртгэлтэй байсан 49,212.0 сая төгрөгийн 1 жилээс дээш хугацаатай зээл, зээлийн хүүгийн өр төлбөрийг урт хугацаат өр төлбөрийн ангилалд шилжүүлэн бүртгэсэн, мөн бэлтгэн нийлүүлэгч компаниудад төлөх өглөг 8,314.6 сая, татварын байгууллагад төлөх өглөг 5,196.7 сая, урьдчилж орсон орлого 1,640.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 112,540.6 сая төгрөг болж 55,873.9 сая төгрөгөөр өссөн нь богино хугацаат өр төлбөр ангиллаас шилжүүлэн бүртгэсэн төгрөгөөр өссөн нь богино хугацаат өр төлбөр ангиллаас шилжүүлэн бүртгэсэн 49,212.0 сая төгрөг, Эрдэнэс таван толгой ХК-иас хүлээн авсан 14,630.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, зээлийн эргэн төлөлт 5,603.5 сая төгрөгөөр буурсантай холбоотой

байна. Урт хугацаат зээлийн эргэн төлөлт хийгдэхгүй байгаа нь Эрчим хүчний зохицуулах хорооноос нүүрсний үнэ тарифыг өртгөөс нь бага үнээр тогтоож ирсэнтэй холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3.20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Багануур ХК-ийн удирдлага үйлдвэрлэл, техник эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Багануур ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар тогтоолоор 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тодотгон баталсан.

Багануур ХК нь тайлант онд 4,625.0 мян.тн нүүрс гаргаж, борлуулах төлөвлөгөөтэй ажиллан, 4,648.4 мян.тн нүүрс гарган 100.5 хувийн гүйцэтгэлтэй, 17,495.0 мян.м3 хөрс хуулах төлөвлөгөөг 102.1 хувийн гүйцэтгэлтэй буюу 17,866.7 мян.м3 хөрс хуулсан. Нийт 28,058.9 мян.м3 уулын цулын ажил гүйцэтгэхээс 29,098.1 мян.м3 уулын цулын ажил гүйцэтгэж, төлөвлөгөөг 103.7 хувиар давуулан биелүүлсэн байна.

Тайлант онд нийт 214,584.0 сая төгрөгийн орлого олж, 224,350.0 сая төгрөгийн зардал гарган 9,766.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 212,597.8 сая төгрөгийн орлого олж 222,114.6 сая төгрөгийн зардал гарган татварын дараах байдлаар 9,516.8 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, төлөвлөсөн алдагдлыг 249.2 сая төгрөгөөр буюу 2.6%-иар бууруулан ажилласан байна.

Тайлант онд үндсэн үйл ажиллагаанаас 212,266.3 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагаанаас 2,317.7 сая төгрөг, нийт 214,584.0 сая төгрөгийн орлого олохоор төлөвлөж гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогоос 210,096.5 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлогоос 2,501.3 сая төгрөг, нийт 212,597.8 сая төгрөгийн орлого олж 99.1 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Уурхайн нүүрсний орлого бүрдүүлэлтийн 48.4 хувь ДЦС-4, 32.5 хувийг ДЦС-3, 5.5 хувийг ДЦС-2, 3.1 хувийг ДДЦС, 0.4 хувийг ЭДЦС, 2.5 хувийг БНДС, АмДС, Налайх ДС, 7.6 хувийг бусад жижиг хэрэглэгчид тус тус бүрдүүлж байна. Жилийн эцсийн нийт дүнгээр тооцоход нэг өдөрт дунджаар 12.6 мян.тн нүүрсийг 194 мянган вагоноор тээвэрлэн, 575.4 сая төгрөгөөр борлуулсан байна.

2022 оны нэг тонн нүүрсний өөрийн өртөг 44,601.40 төгрөг, нэг м³ уулын цулын өртөг 7,105.90 төгрөг байсан бол 2023 онд нэг тонн нүүрсний өөрийн өртөг 47,783.00 төгрөг буюу төлөвлөснөөс 725.10 төгрөгөөр, 1 м³ уулын цулын өртөг 7,633.30 төгрөг буюу төлөвлөснөөс 362.40 төгрөгөөр тус тус хэмнэгдсэн.

Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 42,545.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 34,893.2 сая төгрөг зарцуулсан. Хөрс хуулалт, нүүрс тээврийн 60-90 тн даацтай 4 самосал, овоолгын 1 гинжит бульдозер, нүүрс олборлолтын 6м³ шанагатай 1 гидро экскаватор, үйлчилгээний зориулалттай ачаа суудлын 4 пикап, 10 тн даацтай 2 крантай ачааны машин, 50 тн даацтай 1 автокран, зөөврийн 1 түлш цэнэглэгч машиныг шинээр худалдан авсан. Мөн сүүлийн жилүүдэд хийгдээгүй 12 машинд, илчит тэрэг, төмөр замын краны их засваруудыг хийж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Багануур ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл бэрхитлэл, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох, нөөц өр төлбөрийн үлдэгдлийг баталгаажуулах, НӨАТ-ын тайланд орлогыг зөрүүгүй тайлагнах, худалдан авах ажиллагаатай холбоотой бичиг баримтуудын иж бүрдлийг хангаж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Мишээл-Од Аудит ХХК-ийн ахлах аудитор М.Батмагнай, М.Цэнд-Аюуш, П.Энхцэлмэг, аудитор Х.Гэрэлбаяр, Э.Ундрах-Эрдэнэ, Т.Алтанимэг, Э.Нямдулам нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Э.Энхцэцэг, захирал, тэргүүлэх аудитор Т.Одончимэг нар анхан шатны хяналтыг, Үндэсний аудитын газрын аудитор Ч.Дашдаваа, аудитын менежер Б.Лхагвацэнд, Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Багануур ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2022 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлан, суурь үзүүлэлтийг нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 161,066.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,610.7 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор компанийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, алдагдлыг бууруулах зорилгоор үр ашигтай байх зарчмыг баримталж тайлангийн хугацаанд техник тоног төхөөрөмж, автомашинуудад хийх засвар үйлчилгээнээс 7,518.9 сая төгрөгийг, үйл ажиллагаанаас цахилгааны зардал 115,079.2 сая төгрөг, бичиг хэргийн зардал 22,610.5 сая төгрөг, усны зардал 23,505.2 сая төгрөгийн хэмнэлтийг тус тус бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 558 удаагийн орлого, 821 удаагийн зарлагын мөнгөн гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 23 удаагийн 478.1 сая төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансанд мэдээллээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиглах, хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт 1:

Тендерийн нээлтийн тэмдэглэлийг бүрэн үйлдээгүй, худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичгүүдэд үнэлгээний хорооны гишүүдийн гарын үсэг дутуу, ашиг сонирхлын зөрчилгүйн мэдэгдлийг зарим үнэлгээний хорооны гишүүд бөглөөгүй, хуулийн дагуу заавал үйлдэх баримт бичгүүдийг дутуу үйлдсэн, хурлын тэмдэглэлд гишүүдийн саналыг тодорхой тусгаагүй, буюу тендерийн баримт бичгийн бүрдэл хангалтгүй байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49.1.Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална, гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгалах зөвлөмж хүргүүлэв;

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2023 оны 3-р улирлын санхүүгийн тайланг хамруулж, санхүүгийн тайлангийн бүх дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр 210,507.5 сая төгрөгийн 62 асуудлыг залруулах, ажил сайжруулахаар Багануур ХК-ийн удирдлагад зөвлөмж өгсөний дагуу төлөвлөгөө гарган ажлын хэсэг томилон ажиллаж 49 алдааг залруулсан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 24,293.3 сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага хүргүүлж 90.8 хувийн биелэлттэй, 33.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосныг 100 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	9	24,293.3	9	22,070.4	90.8
Төлбөрийн акт	1	33.0	1	33.0	100.0
Нийт дүн	4	24,326.3	4	22,103.4	90.8

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлуудыг дараагийн аудитаар авч үзэх, дээд шатны байгууллага анхаарал хандуулах шаардлагатай байна. Үүнд:

- Тус компанийн охин компани болох Багануур илч ХХК-ийн санхүүгийн тайланд 280.8 сая төгрөгийн авлага, Багануур сувилал ХХК-ийн санхүүгийн тайланд 896.2 сая төгрөгийн дансны авлага бүртгэлтэй ба авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах болон насжилт өндөртэй авлагыг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх зэрэг арга хэмжээ авч ажиллах шаардлагатай.
- Багануур ХК-ийн охин компаниудын санхүүгийн тайлангийн аудит хийх компанийг Төрийн аудитын тухай хуулийн дагуу сонгон шалгаруулаагүй мөн Үндэсний аудитын газрын хураангуй жагсаалтад тусгагдаагүй аудитын компаниар санхүүгийн тайлангийн аудитыг хийж гүйцэтгүүлсэн зэрэг асуудлыг дээд шатны байгууллага анхаарч ажиллах.
- Охин компани болох Багануур сувилал ХХК нь 1,248.8 сая төгрөгийн хуримтлагдсан ашигтай боловч ногдол ашиг зарлаагүй, Багануур ХК нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг хүртэхгүй байна.
- Тус компанийн санхүүгийн тайланд бүртгэлтэй 2,399.5 сая төгрөгийн өртөгтэй сувиллын барилга болон бусад барилга байгууламжийг Багануур сувилал ХХК-ийн үйл ажиллагаанд үнэ төлбөргүй ашиглуулсан, холбогдон гарсан 101.2 сая төгрөгийн элэгдлийн зардал, ҮХЭХАТ-ийг тус компанийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 73,762.2 сая төгрөгийн 13 алдаа илэрснээс аудитын явцад 72,595.2 сая төгрөгийн 11 алдааг залруулж, 1,167.0 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Өмчийн өөрчлөлтийн тайланд хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдлийг 3,647.6 сая төгрөгөөр, эцсийн үлдэгдлийг 5,128.8 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй, тооцооллын алдаатай тайлагнасан;
2. Бусад авлагын ангилалд тайлагнах 167.5 сая төгрөгийг дансны авлагын ангилалд тайлагнасан, бусад богино хугацаат өр төлбөрийн ангилалд тайлагнах 33.5 сая төгрөгийг дансны өглөгийн ангилалд тайлагнасан;
3. Үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэх шалгуурыг хангасан 1,082.0 сая төгрөгийн хөрөнгийн өртгийг урьдчилж төлсөн зардлын дансанд бүртгэсэн;
4. Техник эдийн засгийн үнэлгээ хийх гэрээт ажлын төлбөрт 2011 оноос өмнөх хугацаанд 550.0 сая төгрөгийг шилжүүлсэн, гэрээ дүгнэсэн актыг аудитад ирүүлсэн боловч огноо нь тодорхой бус, мөн тухайн хугацаанд хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй байсныг алдааны залруулгаар хүлээн зөвшөөрч залруулсан;
5. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт шингээн бүртгэх 2,053.7 сая төгрөгийн зардлыг үйл ажиллагааны бус бусад зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан;

6. Санхүүгийн тайланд бүртгэлтэй нэг орон сууцанд хамаарах элэгдлийн зардлыг 2021 оны 1 сараас эхлэн байгуулаагүйгээс 3.5 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл дутуу тайлагнагдсан;
7. Урсгал засварын зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэх 3,448.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн урсгал зардлыг үндсэн хөрөнгийн өртөгт капиталжуулан бүртгэсэн;
8. Тус компанийн "Няраа" албан тушаалтнууд санхүүгийн хэлтсийн шууд харьяалагдах албан тушаалд бус худалдаа, хангамж хариуцсан хэлтсийн шууд удирдлагад харьяалагдсанаас шалтгаалж санхүүгийн ажилтнуудад тавих хяналт алдагдаж, барва материалыг ирсэн тухай бүр нь бүртгэлд тусгадаггүй, хүлээн авсан болон зарцуулсан 490.0 сая төгрөгийн бараа материалыг санхүүгийн тайланд тусгаагүй байсныг илрүүлж, аудитаар залруулсан;
9. Бусад эргэлтийн бус хөрөнгийн ангилалд тайлагнах 3,609.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн хувь тэнцүүлэн тооцох НӨАТ-ын авлагыг урьдчилж төлсөн зардлын ангилалд тайлагнасан, мөн тайлант хугацаанд НӨАТ-ын авлагаар хүлээн зөвшөөрч бүртгэх 1,913.9 сая төгрөгийн бууралтыг хүлээн зөвшөөрч бүртгээгүй;
10. Богино хугацаат өр төлбөрийн дансанд бүртгэлтэй байсан 49,212.0 сая төгрөгийн 1 жилээс дээш хугацаатай эзэл, эзэлийн хүүгийн өр төлбөрийг урт хугацаат өр төлбөрийн ангилалд шилжүүлэн бүртгэсэн;
11. Орлогын татварын зардлыг 1.4 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.

Аудитаар 14,818.5 сая төгрөгийн 9 зөрчил илэрснээс зөрчлийг давтан гаргахгүй байх 14,409.3 сая төгрөгийн 8 албан шаардлага хүргүүлж, үүнээс 2 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 409.2 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 15,985.5 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 14,374.8 сая төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар хүргүүлсэн "Дараа тайланг журамд заасан хугацаанд хаах, 118.7 сая төгрөгийн дараа тайлангийн авлагын үлдэгдлийг барагдуулах" албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант хугацааны эцэст хугацаа хэтэрсэн 84.9 сая төгрөгийн дараа тайлангийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй байна. Энэ нь Дараа тайлангаар бэлэн мөнгө олгох, зарцуулах журмын 5.1.1-т "сэлбэг бараа материал, бусад хангамжийн зүйлс худалдан авахаар бэлэн мөнгө авсан бол Улаанбаатар хот дотор худалдан авалт хийхээр бэлэн мөнгө авснаас хойш ажлын 10 хоногийн дотор, гадаад улс болон бусад аймаг орон нутагт худалдан авалт хийхээр балан мөнгө олгогдсоноос хойш 10 хоногийн тайланг тушааж тооцоог хийнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

